



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн  
Эрүүл мэндийн яамны дэргэдэх  
Салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.6 дахь хэсэг, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3,2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.5, 5.7, "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.4, 2.9, 5.12 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улс орны хэмжээнд үүссэн онцгой нөхцөл байдлын улмаас Монгол Улсын Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан төрийн албаны тасралтгүй, хэвийн ажиллах, хүний нөөцийг оновчтой удирдах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 53 дугаар тогтоолд заасан хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Гишүүд	Л.Бямбасүрэн	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга
	Б.Цэцэгсайхан	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга
	Д.Нарантуяа	Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын дарга
	С.Эрдэнэтуяа	Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөгөө, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч
	Ш.Мөнгөнцэцэг	Салбарын хууль эрх зүйн нэгдсэн зохицуулалт хариуцсан шинжээч
Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга	С.Ариунтуяа	Төрийн захиргааны удирдлагын газрын Захиргаа, хуулийн хэлтсийн хүний нөөцийн хөгжил хариуцсан ахлах шинжээч

21000324

2.Төрийн албаны тухай хууль тогтоомж, “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, яамны болон салбарын хүний нөөцийн удирдлагыг хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Тус Салбар зөвлөлийн дарга, гишүүдийг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл байгуулах тухай” 2019 оны 312 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ